



БАЙГАЛЬ ОРЧНЫ ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

ХУД-ИЙН 13-Р ХОРОО, ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ХАЙЛААСТ БАГИЙН ЦАГДААГИЙН ХЭЛТСҮҮДЭД ХИЙСЭН АЖИГЛАЛТЫН ДҮН

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ


Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн ТББ нь “Баг, хорооны цагдаагийн байгууллагын байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүргийн хэрэгжилт”-д мониторинг хийхээр Нээлттэй Нийгэм Форумын тэтгэлэгт хөтөлбөрт шалгарсан юм. Тус мониторингийн хүрээнд Улаанбаатар хотын ХУД-ийн 13-р хороо, Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн цагдаагийн хэлтсүүдийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөхийг зорьсон.

Мониторингийн товч дүн, зөвлөмжийг энд онцолсон бөгөөд дэлгэрэнгүй тайланг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.

МОНИТОРИНГИЙН ДҮН

- Байгаль орчны журмын эсрэг улсын хэмжээний гэмт хэрэг, зөрчлийн гомдол мэдээлэл 2012 оноос буурсан (График 1) хэдий ч мониторинг хийсэн нутаг дэвсгэрт хууль бус алт олборлолт, хулгайгаар мод бэлтгэх, тээвэрлэх, хулгайн ан хийх, ус, хөрс зэрэг хүрээлэн буй орчныг бохирдуулах гэмт хэрэг, зөрчил түгээмэл ажиглагдлаа. Гомдол мэдээлэл буурахын зэрэгцээ, хэрэгсэхгүй болгох тоо өсөх хандлагатай байв.


График 1. Байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол



- Байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээлэл нь нийт гомдлын өчүүхэн хувийг эзэлж байна (График 2). Мониторинг хийсэн нутаг дэвсгэрт энэ төрлийн гэмт хэрэг зөрчлийн асуудлаар 7 иргэн, 2 байгууллага нийт 32 гомдол мэдээллийг цагдаагийн байгууллагад хандан гаргажээ.
- Мониторингийн явцад “дээрээс карьер, алтны уурхайг ажиллуул гээд байхад бид юу ч хийгээд нэмэргүй” гэсэн хандлага алба хаагчдаас цухалзаж байсан. Үүнээс үүдэн энэ төрлийн үйлдэлд эвлэрэнгүй хандаж, мэдээлэл хүлээн авахаас цааргалдаг байж болох юм. Нөгөө талаас цагдаагийн алба хаагчид байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил бол иргэд, байгаль хамгаалагч, байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн удирдлага, БОАЖЯ, МХЕГ, төрийн бус байгууллагуудын хийх ажил гэж үздэгээс ирсэн гомдол мэдээллийг хүлээж авахгүй, дээр дурдсан байгууллагууд руу хандахыг зөвлөдөг ажээ. Энэ нь цагдаагийн алба хаагч Зөрчлийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ ухамсарлаагүй, энэ төрлийн хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бэлтгэлгүй байгаатай холбоотой байж болох юм.
- Цагдаагийн байгууллагад мэдээлэл өгсөн иргэнийг нууцлахгүй байгаагаас гэмт хэрэг, зөрчлийг нуун дарагдуулах нөхцөлийг бүрдүүлж байна. Цагдаагийн ажилтан гэмт этгээдэд хандан “чиний эсрэг мэдээллийг энэ хүн өгсөн” гэж хэлсэн тохиолдол мониторингийн явцад гарсан. Цагдаагийн байгууллага нэр хаяггүй болон хүнээр дамжуулж мэдээлэл авахгүй, өөрийн

биеэр хандахыг шаарддаг атлаа мэдээллийг нууцлахгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаар гомдол мэдээлэл гаргахгүй байх нэг нөхцөл болж байна.

График 2. Байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдлын нийт гомдолд эзлэх хувь



- Цагдаагийн алба хаагчид энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд төсөв хүрэлцээгүй, ачаалал их, боловсон хүчин дутмаг, техник тоног төхөөрөмж хоцрогдсон, GPS зэрэг орчин үеийн багаж хэрэгсэлгүй байгаа нь хүндрэлтэй гэдгийг илэрхийлж байв. Нөгөө талаас, хууль хэрэгждэггүй, иргэдийн амьдрал ядуу, эрх зүйн ухамсар дорой, уламжлал

зан заншил алдагдсан, төрийн хяналт шалгалт сул, торгууль шийтгэл бага, урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулдаггүйгээс энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил гардаг гэж иргэд үзэж байна.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийг судалж үзэхэд ХУД иргэний нийгмийн төлөөлөлгүй, ажлаа төлөвлөхдөө аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэхэд илүү анхаардаг нь ажиглагдлаа. Харин Заамар сумын салбар зөвлөл иргэний нийгмийн төлөөлөлтэй, дэргэдээ Байгаль орчны дэд зөвлөлтэй, тусдаа төлөвлөгөө гарган ажилладаг, энэ төрлийн гомдол мэдээллийг хүлээн авсан даруйд ИТХ-ын дарга ажлын хэсэг байгуулан удирдамж батлан, мөрөөр нь хяналт шалгалт хийж, холбогдох арга хэмжээ авдаг байна.
- Мониторингийн явцад бодлогын 9 баримт бичиг, 24 хууль тогтоомж, захиргааны 7 шийдвэртэй танилцаж, 30 төрийн байгууллага, албан тушаалтанд хандсан 38 албан бичиг илгээн албан бичгээр 15, амаар 2 хариу авсан болно. Мониторингийн хугацаа нь Ерөнхийлөгчийн сонгууль, наадам зэрэг чухал үйл явдал болон хүмүүсийн ээлжийн амралттай давхацсанаас үүдэн хэсгийн байцаагчид ихэвчлэн гадуур хамгаалалтад гарах, ээлжийн амралттай байх зэрэг шалтгаанаар ажлын байран дээрээ байгаагүй бөгөөд гомдол мэдээллийг хорооны зохион байгуулагчаар дамжуулан өгөх гэхээр "өөрийн биеэр гарт өг" гэсэн нь чирэгдэл учруулж байсан.

ЗӨВЛӨМЖ

- Байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэх;
- Ялангуяа энэ төрлийн хэрэг, зөрчил нэмэгддэг дулааны улиралд ТББ-аар эргүүл хийлгэж, урамшууллыг олгох;
- Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг шалгах, илрүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төсвөөс санхүүжүүлэх;
- Энэ төрлийн гомдол мэдээлэл гаргасан хүнд хуульд заасны дагуу төлбөр төлөхийн зэрэгцээ, мэдээллийн нууцыг чанд хадгалах, аюулгүй байдлыг нь хангаж ажиллах;
- ЦЕГ-ын дэргэдэх байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх хэлтсийн мэргэжилтнийг энэ төрлийн гэмт хэрэг ихээр гардаг орон нутагт томилон ажиллуулах;
- ХУД-ийн ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүнд иргэний нийгмийн төлөөллийг оруулах, Заамар сумын ГХУСАЗСЗ-ийн Байгаль орчны дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд байгаль хамгаалах чиглэлээр тус орон нутагт ажилладаг ТББ-ын төлөөллийг оруулах.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамьян гүний гудамж -5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 14240,
Утас: (976-11) 313207
Факс: (976-11) 324857

Энэ дугаарт Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн ТББ-аас Байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт сэдвээр хийсэн мониторингийн үр дүнг нийтлэв. Энэхүү мониторинг нь Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн ТББ-аас ирүүлсэн сэдвийн хүрээнд ННФ-ын санхүүжилт болон арга зүйн дэмжлэгтэйгээр хийгдсэн болно.